

БИЧИЛ УУРХАЙГААР АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Энэхүү журам нь ус, цацраг идэвхт элемент агуулсан хүдэр, газрын тос, байгалийн хийгээс бусад төрлийн ашигт малтмалыг бичил уурхайгаар олборлох үйл ажиллагаанд хамаарна.

1.3. Бичил уурхайн үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан хүний үндсэн эрх, эрх чөлөөг дээдлэх, хангах, хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлэн, нэгдэн орсон олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцийг оролцогч бүх талууд мөрдөж ажиллана.

1.4. Бичил уурхайн оролцогч талууд үйл ажиллагаандаа жендэрийн тэгш байдлыг хангаж ажиллана.

Хоёр. Төрийн захиргааны төв байгууллагуудын эрх, үүрэг

2.1. Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

2.1.1. төрөөс эрдэс баялагийн салбарт баримтлах бодлого, стратегийн чиглэлтэй уялдуулан бичил уурхайн талаарх бодлого, үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, зохицуулалтыг удирдлагаар хангах;

2.1.2. бичил уурхайн талаарх Төрийн захиргааны төв байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулах, хүч чармайлтыг нэгтгэн чиглүүлэх, нэгдсэн бодлого, зохицуулалт, удирдлагаар хангах зорилгоор удирдлагын түвшинд харилцан тохиролцсоноор орон тооны бус салбар хоорондын зөвлөл байгуулах;

2.1.3. салбар хоорондын зөвлөлийн бүрэлдэхүүн, удирдлага зохион байгуулалт, чиг үүргийг батлах;

2.1.4. бичил уурхайн үйл ажиллагаанд холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтийг ерөнхий удирдлагаар хангах, бичил уурхайг зохицуулах, газрын асуудлыг шийдвэрлэх, албажуулах, хууль бус ашигт малтмал олборлолтын үйл ажиллагааг зохицуулах чиглэлээр шийдвэр гаргах.

2.2. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

2.2.1. байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажилд бичил уурхай эрхлэгчид¹-ийг татан оролцуулах талаарх бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, зохицуулахад чиг үүргийнхээ дагуу оролцох;

¹ “Бичил уурхай эрхлэгч” гэж бичил уурхай эрхлэх зорилгоор байгуулагдсан Иргэний хуулийн 481.1-д заасан бүртгэгдээгүй нөхөрлөл, Иргэний хуулийн 35 дугаар зүйлд заасан нөхөрлөл болон 36.4-д заасан хоршооны гишүүнийг;

2.2.2. химийн хорт болон аюултай бодисын хэрэглэж байгаа эсэхэд мониторинг, дүн шинжилгээ хийх, түүний хэрэглээг мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран таслан зогсоох арга хэмжээг хэрэгжүүлэх;

2.2.3. орон нутгийн байгаль орчны газар, алба, байгаль хамгаалагчид болон нутгийн захиргааны байгууллагыг бичил уурхай эрхлэгчдийн байгаль орчны хариуцлагыг нэмэгдүүлэх, нөхөн сэргээлт хийх, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай үйл ажиллагаа явуулах дадал, хэвшилд сургахад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх.

2.3. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

2.3.1. бичил уурхай эрхлэгчдийн нийгмийн хамгааллын асуудлыг сайжруулах талаарх бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх, зохицуулахад чиг үүргийнхээ дагуу оролцох;

2.3.2. бичил уурхай эрхлэгчдийн нийгмийн хамгааллыг сайжруулах, нийгмийн суурь үйлчилгээнд хамруулах зорилгоор нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллага, нийгмийн үйлчилгээний төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтарч уялдааг хангаж ажиллах;

2.3.3. бичил уурхай эрхлэгчдийг нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал болон нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах;

2.3.4. зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагаанд бичил уурхай эрхлэгч амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрхүүдийг хамруулан, тэдний амьжиргааг дээшлүүлэх арга хэмжээ авах;

2.3.5. бичил уурхайд хөдөлмөр эрхэлж байгаа насанд хүрээгүй хүүхдийг бичил уурхайгаас хөндийрүүлэх, таслан зогсоох арга хэмжээ авах;

2.3.6. бичил уурхай эрхлэгчдийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын хөтөлбөр боловсруулах, сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулахад оролцох;

2.3.7. бичил уурхайд гарч буй үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний төлөв байдал, шалтгаан нөхцөл, үр дагаврын талаар судалгаа хийх, зөвлөмж, санал боловсруулах.

2.4. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

2.4.1. бичил уурхай эрхлэгчид тэдний гэр бүлийн гишүүдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчин, мэргэжлээс шалтгаалах өвчин, халдварт болон халдварт бус өвчинд өртөх эрсдлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах мэдлэг ойлголттой болгох талаар салбарын бодлого, хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах, түүний хэрэгжилт, зохион байгуулалтыг удирдлагаар хангах;

2.4.2. бичил уурхай бүхий орон нутгийн эмч, эмнэлгийн ажилтнуудын бичил уурхай эрхлэгчдийн химийн бодисын хордлого, ажил, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг оношлох, эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх чадавхийг дээшлүүлэх арга хэмжээг зохион байгуулахад нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангах.

Гурав. Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрх, үүрэг

Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.1. Ашигт малтмалын тухай хуулийн 11.1.23-д заасан дүгнэлтийг ажлын 10 хоногт багтаан гаргаж сум, дүүргийн Засаг даргад хүргүүлэх, шаардлагатай тохиолдолд газар дээр нь ажиллах;

3.2. Бичил уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан газрыг кадастрын зураг зүйн нэгдсэн бүртгэлд бүртгэх, бичил уурхайгаар ашигт малтмал олборлох явцад Ашигт малтмалын тухай хуулийн 11.1.23-д заасан орд илрээгүй тохиолдолд дүгнэлтийг цуцлах;

3.3. Бичил уурхай эрхлэгчдийн мэдээллийн санг хөтлөх, судалгаа хийх, санал дүгнэлт гаргаж тайланг жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан геологи уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

3.4. Бичил уурхай эрхлэгчид, нутгийн өөрөө удирдах болон засаг захиргааны байгууллагын ажилтнуудад бичил уурхайн эрх зүйн орчин, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа болон байгаль орчны нөхөн сэргээлт хийх талаар чадавхижуулах сургалт явуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;

3.5. Бичил уурхай эрхлэх боломжтой газрын судалгаа гаргаж, мэдээллийн сан үүсгэж хөтлөх.

Дөрөв. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын эрх, үүрэг

Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

4.1. Бичил уурхайн үйл ажиллагаанд холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах, төрийн бодлого болон энэхүү журмын хэрэгжилтийг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

4.2. Аймаг, нийслэлийн Засаг даргын бичил уурхайн талаар авч хэрэгжүүлж буй ажлын тайланг сонсож чиглэл, зөвлөмж өгөх.

Тав. Аймаг, нийслэлийн Засаг даргын эрх, үүрэг

Аймаг, нийслэлийн Засаг дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

5.1. Бичил уурхайн үйл ажиллагаанд холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах;

5.2. Бичил уурхайн зориулалтаар тусгай хэрэгцээнд авсан газар, бичил уурхай эрхлэгчид, тэдгээрийн үйл ажиллагааны талаарх нэгдсэн судалгаа, мэдээллийн сан бүрдүүлэх, төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх, оролцогч талуудад мэдээлэх;

5.3. Бичил уурхай эрхлэгч этгээдийн үйл ажиллагааны талаарх сумын Засаг даргын тайлан, мэдээллийг хэлэлцэн зөвлөмж, чиглэл өгөх;

5.4. Бичил уурхай эрхлэгч этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавьж, Аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлыг мэдээллээр хангах;

5.5. Өөрийн бүрэн эрхийн хүрээнд харъяалах байгууллагуудад бичил уурхайн үйл ажиллагаатай холбогдох дараах чиг үүрэг өгч, удирдлагаар хангаж ажиллана:

5.5.1. бичил уурхай эрхлэгчид тэдний гэр бүлд суурь болон экологийн тусгай боловсрол олгоно;

5.5.2. бичил уурхайгаар олборлолт явуулсан газарт нөхөн сэргээлт хийлгэх ажилд хяналт тавина;

5.5.3. бичил уурхайн осол гэмтэл, байгалийн болон давагдашгүй хүчин зүйлс, үүсч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, сургалт сурталчилгаа зохион байгуулах, осол гэмтэл гарсан тохиолдолд цаг алдалгүй авран туслах үйлчилгээ үзүүлнэ;

5.5.4. бичил уурхайн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны холбогдох дүрэм, журам, аргачлалын хэрэгжилтэд хяналт тавина;

5.5.5. хөдөлмөрийн аюулгүй байдал, уул уурхайн мэргэшүүлэх сургалтад хамруулна;

5.5.6. хөнгөлөлттэй зээл, төсөл, хөтөлбөрт хамруулах, өөр ажлын байраар хангах ажлыг зохион байгуулна;

5.5.7. бичил уурхай эрхлэгчдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх, эрүүл мэндийн үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулна.

Зургаа. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын эрх, үүрэг

Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

6.1. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох зорилгоор Бичил уурхайг эрхлэгч этгээдийн гаргасан хүсэлтийг үндэслэн Газрын тухай хуулийн 16.1.11-д заасан зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авах газрыг сонгох;

6.2. Бичил уурхайн зориулалтаар сонгосон газрын талаар Ашигт малтмалын тухай хуулийн 11.1.23-т заасан дүгнэлт гаргуулах тухай шийдвэрийг сум, дүүргийн Засаг даргад хүргүүлэх;

6.3. Бичил уурхайн зориулалтаар олгох боломжтой гэсэн дүгнэлт гарсан газрыг бичил уурхайн зориулалтаар тусгай хэрэгцээнд авах тухай шийдвэрийг ажлын 15 хоногт багтаан гаргах;

6.4. Бичил уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан тухай шийдвэрийг Ашигт малтмалын тухай хуулийн 14.1 дэх хэсэгт заасны дагуу төрийн захиргааны байгууллага² -д хүргүүлэх;

6.5. Гаргасан шийдвэрээ ажлын 5 хоногт багтаан хүсэлт гаргасан бичил уурхай эрхлэгч этгээдэд хүргүүлэх.

Долоо. Сум, дүүргийн Засаг даргын эрх, үүрэг

Сум, дүүргийн Засаг дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

² “төрийн захиргааны байгууллага” гэж Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагыг;

- 7.1. Бичил уурхай эрхлэгчдийг зохион байгуулалтад ороход нь эрх зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх;
- 7.2. Энэхүү журмын 7.2-т заасан шийдвэр гарснаас хойш ажлын 10 хоногт багтаан Ашигт малтмалын тухай хуулийн 11.1.23-т заасан дүгнэлт гаргуулах хүсэлтийг төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;
- 7.3. Энэхүү журмын 7.3-т заасан шийдвэрийг үндэслэн хүсэлт гаргасан бичил уурхай эрхлэгч этгээд³ -тэй бичил уурхайгаар ашигт малтмал олборлох тухай гэрээг тухайн талбай дахь ашигт малтмалыг ашиглаж дуусах хүртлэх хугацаагаар байгуулна, гэрээний хугацааг нэг, нэг жилээр сунгаж болно;
- 7.4. Бичил уурхай эрхлэгч эдгээд нь төрийн захиргааны байгууллагаас бичил уурхай эрхлэх боломжтой гэсэн дүгнэлт гаргасан талбайд үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд хяналт тавих;
- 7.5. Энэхүү журмын 12.3, 12.4-т заасны дагуу нөхөн сэргээлт хийгээгүй буюу Ашигт малтмал олборлох гэрээний үүргээ биелүүлээгүй бичил уурхай эрхлэгч этгээдтэй ашигт малтмал олборлох гэрээг сунгахгүй, өөр талбайд дахин гэрээ байгуулахгүй байх;
- 7.6. Сум, дүүргийн хэмжээнд бичил уурхайн зориулалтаар авсан газрын зураг зүйн нэгдсэн бүртгэл хөтлөх;
- 7.7. Бичил уурхай эрхлэгчидийг эрүүл мэндийн болон нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх, эрүүл мэнд, нийгмийн даатгалд хамруулах;
- 7.8. Бичил уурхай эрхлэгч этгээдийн олборлолт явуулсан талбайд энэхүү журмын 12.3, 12.4 болон 4 дүгээр хавсралтад заасан Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу нөхөн сэргээлт хийлгүүлэх;
- 7.9. Бичил уурхай эрхлэгч этгээдийн нөхөн сэргээлт хийсэн талбайг комисс томилж, хүлээж авах, энэ тухай мэдээ тайланг мэргэжлийн хяналтын байгууллагад хүргүүлэх;
- 7.10. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон энэхүү журмын 5 дугаар хавсралтад заасан Бичил уурхайн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих;
- 7.11. Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2, 3.1.3-д заасан химийн бодисыг хэрэглэх, хадгалж буй эсэхэд хяналт тавих;
- 7.12. Энэхүү журмын 6 дугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу тайлан гаргаж төрийн захиргааны байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг даргад жил бүрийн 03 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлэх;
- 7.13. Бичил уурхай эрхлэгчид болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн амьдрах суурьшлын бүсийг тогтоох;

³ “бичил уурхай эрхлэгч этгээд” гэж бичил уурхай эрхлэх зорилгоор орон нутгийн иргэдийн үүсгэн байгуулсан Иргэний хуулийн 481.1-д заасан бүртгэгдээгүй нөхөрлөл, Иргэний хуулийн 35 дугаар зүйлд заасан нөхөрлөл болон 36.4-д заасан хоршоог;

7.14. Бичил уурхайн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт хийх дундын тусгай сан байгуулж, захиран зарцуулах ажлыг хамтран зохион байгуулах.

Найм. Бичил уурхай эрхлэгч этгээдийн эрх, үүрэг

8.1. Бичил уурхай эрхлэгч этгээд нь дараах үүрэг хэрэгжүүлнэ:

8.1.1. олборлолтын талбай дээр дараах бичиг баримтыг байлгана:

8.1.1.1. бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээ;

8.1.1.2. бичил уурхай эрхлэгчдийн бүртгэл;

8.1.1.3. үүсгэн байгуулах гэрээ, Нөхөрлөл, хоршооны улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар.

8.1.2. бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээний үүргийг биелүүлэх;

8.1.3. энэхүү журмын 4 дүгээр хавсралтад заасан Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу нөхөн сэргээлт хийж хүлээлгэн өгөх,

8.1.4. энэхүү журмын 5 дугаар хавсралтад заасан Бичил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийг дагаж мөрдөх;

8.1.5. бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээ байгуулахад байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хавсаргах;

8.1.6. орон нутгийн засаг захиргаанаас тогтоож өгсөн талбайд суурьшлын бүс, хог хаягдлын цэг байгуулах;

8.1.7. бичил уурхай эрхлэгчдийг эрүүл мэнд, нийгмийн даатгалд хамруулах;

8.1.8. тэсэлгээний ажлын тусгай зөвшөөрөлтэй этгээдээр мэргэжлийн хяналтын төв байгууллагаас олгосон хяналтын хуудсын үндэслэл дор гүйцэтгүүлэх;

8.1.9. олборлосон ашигт малтмалыг холбогдох хууль тогтоомжийн дагуу борлуулах;

8.1.10. бичил уурхай эрхлэгч нь үйл ажиллагааны жилийн тайлангаа төрийн захиргааны байгууллагад дараа оны 03 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлэх.

8.2. Бичил уурхай эрхлэгч этгээд нь дараах эрх эдлэнэ:

8.2.1. бичил уурхайгаар ашигт малтмал олборлох тухай гэрээ байгуулах өргөдөл гаргах;

8.2.2. бичил уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд газар авсан эсэх талаарх шийдвэрийг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас авах;

8.2.3. бичил уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан газарт Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох тухай гэрээ байгуулахаар гаргасан өргөдлийн бүртгэгдсэн дарааллын дагуу гэрээ байгуулах;

8.2.4. олборлосон ашигт малтмалыг малтмалыг баяжуулах, боловсруулах, борлуулах, тээвэрлэх.

Ес. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох газар

9.1. Бичил уурхайн зориулалтаар ашиглуулах нэг газрын хэмжээ 5 га-аас ихгүй байна.

9.2. Нэг сум, дүүргийн нутаг дэвсгэрт бичил уурхайн зориулалтаар ашиглуулах газрын хэмжээ 50 га-аас илүүгүй байна.

9.3. Энэхүү журмын 3 дугаар хавсралтад заасан маягтын дагуу сум, дүүргийн Засаг дарга, тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөөтэй ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч, бичил уурхай эрхлэгч этгээдийн хооронд байгуулсан гурвалсан гэрээгээр бичил уурхай эрхлэгч этгээдэд талбай ашиглуулж болно.

9.4. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү журмын 10.3-д заасны дагуу уурхайн эдэлбэр газраас бичил уурхай эрхлэгч этгээдэд талбай ашиглуулсан нь Ашигт малтмалын тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан байгаль орчныг хамгаалах талаар ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

Арав. Ашигт малтмал олборлох гэрээ байгуулах тухай өргөдөл гаргах, түүнийг хянан шийдвэрлэх

10.1. Бичил уурхай эрхлэгч этгээд нь Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээ байгуулах тухай өргөдлөө сум, дүүргийн Засаг даргад энэхүү журмын 1 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу бичгээр гаргана.

10.2. Өргөдөлд дараах баримт бичгийг хавсаргана:

- 10.2.1. үүсгэн байгуулсан гэрээ, дүрмийн хуулбар;
- 10.2.2. бичил уурхай эрхлэгчдийн иргэний үнэмлэхний хуулбар;
- 10.2.3. нөхөрлөл буюу хоршооны улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
- 10.2.4. олборлолт явуулах талбайн байршлын зураг;
- 10.2.5. бичил уурхай эрхлэгчдийн албан татвар төлөгчийн гэрчилгээний хуулбар;
- 10.2.6. бичил уурхай эрхлэгчдийн эрүүл мэнд, нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар.

10.3. Бичил уурхай эрхлэгчид дараах шаардлага тавигдана:

- 10.3.1. Монгол Улсын иргэн байх;
- 10.3.2. 18 нас хүрсэн байх;
- 10.3.3. тухайн орон нутагт оршин суугчаар бүртгүүлсэн байх.

10.4. Энэхүү журмын 10.1-10.3-т заасан шаардлага хангаагүй өргөдлийг хүлээн авахгүй.

10.5. Сум, дүүргийн Засаг дарга өргөдлийг хүлээн авснаас хойш ажлын 30 хоногт багтаан шаардлага хангасан бичил уурхай эрхлэгч этгээдтэй өргөдлийн бүртгэгдсэн дарааллын дагуу энэхүү журмын 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээ байгуулна.

Арван нэг. Талбайг буцааж хүлээлгэн өгөх, цуцлах

11.1. Бичил уурхай эрхлэгч этгээд дараах тохиолдолд талбайг буцааж хүлээлгэн өгнө:

- 11.1.1. хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцлөөс шалтгаалан олборлолтыг үргэлжлүүлэх боломжгүй болсон тухай эрх бүхий улсын байцаагчийн дүгнэлт гарсан;

11.1.2. бичил уурхай эрхлэгч этгээд өөрөө талбайг хүлээлгэн өгөх хүсэлт гаргасан, гэрээг цуцалсан;

11.2. Гэрээг хугацаанаас өмнө цуцалсан нь бичил уурхай эрхлэгч этгээдийг олборлолт хийсэн тухайн талбайд байгаль орчны нөхөн сэргээлт хийх үүргээс чөлөөлөхгүй.

11.3. Бичил уурхай эрхлэгч этгээд талбайг буцаан хүлээлгэж өгөхдөө энэхүү журмын 4 дүгээр хавсралтад заасан аргачлалын дагуу нөхөн сэргээлт хийж, сум, дүүргийн Засаг даргын томилсон комисст актаар хүлээлгэн өгнө.

11.4. Нөхөн сэргээлт хийгээгүй орхигдсон газарт олборлолт явуулж байгаа тохиолдолд тухайн бичил уурхай эрхлэгч этгээдийн олборлолт хийсэн газарт энэхүү журмын 4 дүгээр хавсралтад заасан аргачлалын дагуу нөхөн сэргээлт хийнэ.

Арван хоёр. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлоход хориглох зүйлс

12.1. 18 нас хүрээгүй иргэнийг ажиллуулах;

12.2. Энэхүү журмын 5 дугаар хавсралтад заасан Бичил уурхайн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм зөрчих;

12.3. Албан татвар төлөхөөс зайлсхийх;

12.4. Гишүүн бус иргэн, гадаадын иргэн, харъяалалгүй иргэнийг ажиллуулах;

12.5. Химийн хорт болон аюултай бодис ашиглах;

12.6. Тусгай зөвшөөрөлгүйгээр тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглах;

12.7. Гэрээгээр олгосон талбайг бусдад шилжүүлэх, барьцаалах, худалдах, түрээслэх;

12.8. Ашигт малтмал олборлолтын үйл ажиллагаанд 3500 см³-ээс дээш багтаамжтай дотоод шаталтат хөдөлгүүр бүхий механизмыг ашиглах;

12.9. Энэхүү журмын 10.3-т заасан гурвалсан гэрээг байгуулахгүйгээр ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн талбайд үйл ажиллагаа явуулах;

12.10. Олборлолтын талбайд 18 нас хүрээгүй хүнийг байлгах.

Арван гурав. Хяналт тавих, хариуцлага хүлээлгэх

13.1. Энэхүү журмын хэрэгжилтэд мэргэжлийн хяналтын төв болон орон нутгийн байгууллага, төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллага хяналт тавьж ажиллана.

13.2. Энэхүү журмыг зөрчсөн иргэн, хуулийн этгээд, албан тушаалтанд Ашигт малтмалын тухай хуулийн 66.1.9-д заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.